



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/128

Арвайхээр сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.7.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Үсчин, гоо сайханчдын холбооны гишүүн Сүхбаатарын Баярмаад 2024 оны Дэлхийн аварга шалгаруулах (цахим) тэмцээнд оролцоход шаардлагатай бүртгэлийн зардал 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0300